

ДАХИН ГЭРЛЭСЭН ГЭР БҮЛТЭЙ АЖИЛЛАХ НИЙГМИЙН АЖЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Ч. Должинсүрэн

Доктор (Ph.D), дэд профессор

Шинжлэх ухаан, технологийн их сургууль

Нийгэм, хүмүүнлэгийн сургууль

doljinsuren012@gmail.com

Хураангуй: Монгол Улсад гэр бүл салалтын тоо жилээс жилд өсөж, улмаар дахин гэрлэлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Дахин гэрлэсэн гэр бүлүүд нь өмнөх харилцаанаас үүссэн сэтгэл зүйн дарамт, хүүхдүүдийн зохицуулалт, хүлээлт зөрөлдөх зэрэг олон талт асуудалтай тулгардаг. Иймд эдгээр гэр бүлүүдэд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ зайлшгүй шаардлагатай болсон. Энэхүү өгүүлэлд дахин гэрлэсэн гэр бүлийн онцлог, тулгарч буй асуудлыг судалж, тэдэнд үзүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээний өнөөгийн төлөв байдал, хомсдол, хүртээмжийн талаар дун шинжилгээ хийсэн.

Түлхүүр үг: дахин гэрлэлт, гэр бүл, нийгмийн ажил, үйлчилгээ

УДИРТГАЛ

Дахин гэрлэсэн гэр бүл гэдэг нь өмнө нь гэр бүл зохиож байсан хосууд хоорондоо гэрлэх явдал юм. Гадаадын улс орнуудад уг үзэгдлийг тайлбарлахдаа “холимог гэр бүл”, “2 дахь гэр бүл” (англи хэлэнд “step family”) хэмээн томъёолсон байдаг. (Cartwright. С., 2012). Монгол улсад 2024 оны байдлаар Монгол Улсад албан ёсоор гэрлэлтээ батлуулсан болон гэр бүлээ цуцлуулсан гэр бүлийн тооны талаар Үндэсний статистикийн хорооноос албан ёсны мэдээлэл хараахан нэгтгэсэн гараагүй байна. 2023 оны байдлаар албан ёсоор гэрлэлтээ батлуулсан гэр бүлийн тоо 17408 байна. Харин албан ёсоор гэр бүлээ цуцлуулсан тоо 12743 болж, өмнөх жилүүдтэй харьцуулахад 28.8 хувиар өссөн нь нийт гэрлэлтийн дөрөвний нэгтэй

тэнцэж байна байна. (2025). Гэр бүлээ цуцлуулж буй тэргүүлэх шалтгаанынэгдүгээртгэр бүлийн хүчирхийлэл, архидалт, үл ойлголцлын асуудлууд ордог байна.Хоёрдугаарт, гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцаа, харингуравдугаартхолын зай гэх шалтгаанууд нэрлэгджээ.Сүүлийн жилүүдэд гэр бүлийн тогтвортой байдал алдагдсанаар гэр бүлийн уур амьсгал, дотор нь өсөж торниж буй хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлууд газар авсаар байна. (Гэр бүлийн хөгжлийн үнэлгээ: Судалгааны тайлан, 2021) АНУ-ын судлаачдын тогтоосноор одоогийн байдлаар АНУ-д гэр бүл болоод салсан эрчүүдийн 50 хувь нь, эмэгтэйчүүдийн 33 хувь нь гэр бүлээ цуцлуулаад 1 жил өнгөрсний дараагаар дахин гэр бүлтэй болдог

байна, харин 3 жилийн дараагаар бол эрчүүдийн 83 хувь нь, эмэгтэйчүүдийн 75 хувь нь дахин гэрлэдэг гэсэн тоо гарчээ. Хүүхэдтэй салсан эмэгтэйчүүдийн 50-с дээш хувь нь салсны дараах 5 жилд багтан дахин гэрлэдэг бол 5 хувь нь 10 жилд багтан дахин гэрлэдэг. (Netherington, 2000). Монгол улсын хувьд дахин гэрлэлтийн асуудал нийгмийн шинжлэх ухаанд төдийлөн тусгагдаж гарч ирээгүй байгаа боловч бодит амьдрал дээр тус асуудал нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн анхаарах шаардлагатай асуудлуудын нэг болсон байна.


Дахин гэрлэсэн гэр бүлийн хөгжлийн онцлог нь анхны гэр бүлийг бодвол илүү нарийн, төвөгтэй байдаг. Тэрээр энгийн гэр бүлийн хөгжлийн үе шат дээр нэмээд салалтын шат, бүрэн бус гэр бүлийн шат, дахин гэрлэх шат зэргийг багтаадаг. Иймд нийгмийг бүрэлдүүлж байгаа анхдагч нэгж болох гэр бүлийг дахин бий болоход тогтвортой, зөрчилгүй, тайван байдлаар дахин эхлэхэд дэмжих шаардлагатай байна.

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

Монгол улсад 2023 оны байдлаар албан ёсоор гэрлэлтээ батлуулсан гэр бүлийн тоо 17 408 байна. Гэрлэлтээ бүртгүүлсэн хүмүүсийн насны хувьд авч үзэхэд эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль аль нь 25-29 нас хамгийн их байна.


Зураг 1. Монгол улсад 2023 оны байдлаар гэрлэлт бүртгүүлсэн хүмүүсийн нас, хүйс

Харин албан ёсоор гэр бүлээ цуцлуулсан тоо 12743 байна. Энэ



үр дүнд үндэслэн тооцсон гэр бүл салалтын түвшин 2.2 (1000 хүн амд)гэр бүл салсан гэсэн үг юм. Гэрлэлт цуцлалтыг хамтран амьдарсан хугацаагаар нь авч үзвэл залуу гэр бүлийн цуцлалт харьцангуй бага түвшинд харин 10 ба түүнээс дээш жил амьдарсан хосуудын салалтын түвшин өндөр байна. Энэ нь улс орны хөгжил, хэрэгжиж буй хууль тогтоомжтой холбоотой байх магадлалтай.

Зураг 2. Гэр бүл цуцлалт, гэр бүл байсан хугацаагаар



Гэр бүл салалтын шалтгааныг маш олон талаас тайлбарладаг ч дараах шалтгаануудыг нэрлэж байна.

Монгол улс дахь гэр бүл салалтын шалтгааныг эрэмбэлбэл

1. Зан харьцаа таарамжгүй
2. Архи, согтууруулах ундааны хэт хэрэглээ
3. Гэр бүлийн хүчирхийлэл
4. Эдийн засгийн хүндрэл

5. Харилцан үл ойлголцол, итгэл алдрал
6. Гадаадад удаан хугацаанд ажиллах, амьдрах
7. Гэр бүлээс гадуурх харилцаа
8. Гэр бүлийн соёлын ялгаа
9. Гэр бүлийн гишүүд хариуцлага бүрэн ухамсарлаагүй
10. Гэрлэх хүнээ сайн таньж мэдээгүй
11. Шилжилт хөдөлгөөн
12. Хэрүүл маргаан, үл ойлголцол. (Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал., 2023), (Гадаад ажил эрхлэлтийн гэр бүлд үзүүлэх нөлөөлөл., 2022), (Монгол гэр бүл дэх гуравдагч этгээдийн оролцооны судалгаа., 2023)

Монгол гэр бүлд зонхилон тохиолдож буй гэр бүл салалтын шалтгааныг судлаач Б.Оюун-Эрдэнийн судалснаар “Монгол улсад явагдсан нийгмийн шилжилтийн үе болон дэлхий дахины даяарчлал, соёлын глобалчлал нь монгол гэр бүлийн бүтэц, хэв маягт ихээхэн өөрчлөлтийг авчирч байна”. (Оюун-Эрдэнэ.Б, 2012). Тус судалгаагаар монгол гэр бүлийн өмнө тулгамдаж буй нэгэн асуудал нь улс дамнасан гэр бүл буюу гэр бүлийн аль нэг гишүүн гадаадад суралцах эсвэл ажиллах зорилготойгоор гэр бүлээсээ хол амьдрах асуудал гэж тодорхойлогджээ.

Гадаадад ажиллагчдын дийлэнх хувь нь хөдөлмөрийн насны эрчүүд эзэлж байгаагаас 53,5 хувь гэр бүлтэй боловч дийлэнх хувь нь гэр бүлтэйгээ хамт байж чадахгүй байгаа нь гэр бүлийн бат бөх байдал, салалтад, мөн цаашлаад дахин гэр бүл болох байдалд шууд нөлөө үзүүлж байна гэж хэлж болно. Сүүлийн жилүүдэд гэр бүлийн тогтвортой байдал алдагдсанаар гэр бүлийн уур амьсгал, дотор нь өсөж торниж буй хүүхдүүдийн нийгэм-сэтгэл зүйн асуудлууд газар авсаар байна.

КЕЙС-ийн дүн шинжилгээ

Дахин гэрлэсэн 27-50 насны нийт 15 хүнийг кейс дүн шинжилгээнд хамруулав. Үүнд 6 буюу 40% нь эрэгтэй, 9 буюу 60% нь эмэгтэй байв.

График 1. Кейс хамрагдсан хүмүүсийн хүйсийн харьцаа




Ажил эрхлэлтийн хувьд 6 эрэгтэйчүүдийн 3 нь үндсэн ажилтай 2 нь тогтсон ажилгүй улирлын чанартай, 1 нь ажил хийдэггүй. 9 эмэгтэйчүүдийн 5 нь үндсэн ажилтай. 4 нь хувиараа хөдөлмөр эрхлэж байна.

График 2. Ажил эрхлэлтийн байдал



Ам бүлийн байдлын хувьд 2-4 ам бүлтэй 6 гэр бүл, 4-6 ам бүлтэй 9 гэр бүл байна. Өрхийн орлогын хувьд 65% нь 1.000.000-1.500.000, 14% нь 1.500.001-2.000.000, 14% нь 2.000.000- дээш орлоготой, 7% нь 500.000-1.000.000 төгрөгийн орлоготой байна.

График 3. Өрхийн орлого



Дахин гэрлэлттэй холбоотой мэдээллүүд

9 эмэгтэйчүүдийн 7 нь өмнө нь гэр бүл зохиож байсан ба 6 нь

хүүхэд төрүүлсэн. 6 эрэгтэйчүүдээс 4 нь гэр бүл өмнө нь зохиож хүүхэдтэй байсан бол үлдсэн 2 эрэгтэй нь өмнө нь гэр бүл зохиож байгаагүй бөгөөд хүүхэдгүйгээр дахин гэрлэсэн байна.

График 4. Өмнө гэр бүл зохиож, хүүхэдтэй байсан эсэх





График 5. Дахин гэрлэсэн гэр бүлийн эхнэр/нөхөр асуудлаа шийдвэрлэхдээ хэнд ханддаг болох



Кейст хамрагдсан хүмүүсээс эдийн засгийн болоод сэтгэл зүйн асуудлаа шийдвэрлэхэд бусдын туслалцааг авахдаа эрэгтэйчүүд аль болох өөрсдөө шийдэх гэж оролддог эсвэл гэр бүлийн хүнтэйгээ хамтран шийдвэрлэх арга замыг сонгодог байна. Эмэгтэйчүүдийн хувьд харин гэр бүлийн бусад гишүүд буюу өөрийн төрсөн аав,

ээж эсвэл эгч дүү нартаа хэлж туслалцаа хүсдэг мөн найз нөхдөдөө ханддаг, цөөн үлдсэн хэсэг нь гэр бүлийн хүнтэйгээ хамтран асуудлаа шийддэг байна. Гэвч эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн аль нь ч тулгарсан асуудал бэрхшээлээ шийдвэрлэхдээ мэргэжлийн хүнд ханддаггүй байна.

Хүснэгт 1. Дахин гэрлэсэн гэр бүлд тулгардаг асуудлууд

Тулгарч буй асуудлууд	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	Нийт
Эдийн засгийн асуудал	+	+				+	+		+						+	6
Амьдрах газрын асуудал	+	+													+	3
Хүүхдүүдийн харилцааны зөрчлийн асуудал			+		+				+		+	+				5
Хүүхэд болон хойд ээж/аавын харилцааны зөрчил			+				+			+		+	+			5
Хардалт үл итгэлцэл		+	+						+		+	+	+		+	7
Бие махбодийн хүчирхийлэл									+		+					2
Эдийн засгийн хүчирхийлэл						+		+		+			+			4
Сэтгэлзүйн хүчирхийлэл		+	+							+		+	+			5
Хадам талын сөрөг харилцаа					+			+						+		3
Нийгмийн зүгээс үзүүлэх сэтгэл зүйн хүчирхийлэл							+									1
Дахин гэрлэсэн хосуудын харилцааны зөрчил	+	+	+		+				+	+	+			+	+	9
Өмнөх гэр бүлтэй холбоотой асуудал			+												+	2
Архи согтууруулах унлаанаас үүдэлтэй зөрчил			+					+	+		+			+	+	6

Дахин гэрлэсэн 15 гэр бүлийн кейс дээрх асуудлыг жагсаахад 13 асуудал байв.

- Гэр бүлүүдэд 9 буюу 60% нь түгээмэл тулгарч буй асуудалд **хосуудын харилцааны зөрчил** байна. Харилцаа эхэндээ хэвийн байсан ч хэсэг хугацааны дараа аливаа асуудал дээр зөрчилдөхдөө асуудлаа шийдвэрлэхдээ нэг нэгнээ хүлээн зөвшөөрч, хүлээцтэй хандаж чадахгүй асуудлыг хэлэлцэн шийдэх бус улам дэвэргэж лавшруулдаг байна.
- Үүнээс 7 гэр бүлд буюу 53% хувьд нь хосууд нэгнээ **хардах болон үл итгэх асуудал** тулгарч байна. Энэ нь өмнөх амьдралаас авсан сэтгэлийн шарх эсвэл дахин энэ амьдралаа алдах байх гэсэн хэт санаа зовнилоос үүдэх хандлагатай байна.
- Удаах нь 6 гэр бүл буюу 40% нь **эдийн засгийн хувьд асуудалтай** эхнэр эсвэл нөхрийн хувьд тогтсон ажилгүй улирлын чанартай ажил хийх, ажил хийж байгаа ч цалин орлого бага байх нь гэр бүлүүдийн хувьд асуудал болж байна.
- Дахин гэрлэсэн гэр бүлийн хувьд бусад гэр бүлтэй харьцуулбал өвөрмөц шинж чанар ихтэй эхнэр/нөхрийн аль нэг нь хүүхэдтэй дахин гэрлэх эсвэл хоёулаа хоёр талаасаа хүүхэдтэй байх нь элбэг. Бүгд өөр өөрийн гэсэн онцлог шинжтэй, тогтсон хэв маягтай гэр бүл дахин шинээр өөр гэр

бүлтэй нэгдэж байгаа учир **харилцааны зөрчил** их гардаг. 15 кейсийн 5 гэр бүл буюу 33% нь хүүхэдтэй дахин гэрлэсэн бөгөөд бүгд хойд ээж/аав нь хүүхэдтэйгээ харилцааны зөрчилтэй байна. Үүнээс гадна **дагавар хүүхдүүд хоорондоо харилцааны зөрчил** ихтэй байна.

- Дахин гэрлэсэн гэр бүлийн хувьд эхнэр нөхөр 2 нэг нэгнээ **сэтгэлзүйн хүчирхийлэлд** оруулах, эсвэл хүүхдүүдээ хүчирхийлэх тохиолдол 5 гэр бүл буюу 33% нь ажиглагдаж байна.
- Мөн эрчүүдийн хувьд **согтууруулах ундааны хэрэглээ ихтэй** гэр бүл 6 буюу 40% байна. Согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ биеэ хянах чадвараа алдаж гэр бүлийн гишүүндээ **бие махбодын хүчирхийлэл** үзүүлсэн тохиолдол 2 гэр бүлд буюу 13% байна.
- 3 гэр бүл буюу 20% нь **амьдрах орон байрны асуудалтай** учир нь өмнөх амьдралаа дуусгавар болгох үед эрэгтэйчүүд өмнөх эхнэртээ амьдарч байсан орон гэрээ үлдээх эсвэл хамтын хөрөнгөө зарж хуваасан байдаг учир дахин гэр бүл болоход орон байрны асуудал тулгарч байна. Мөн **хадам талын гишүүдтэй харилцах харилцааны** тал дээр асуудалтай тэр тусмаа дахин

гэрлэж буй эмэгтэй хүүхэдтэй байвал нөхрийн талынхан хүлээн зөвшөөрдөггүй эсэргүүцэх хандлага ихтэй.

- Дахин гэрлэсэн гэр бүл нь өмнөх амьдралаа янз бүрийн учир шалтгааны улмаас үргэлжлүүлэх боломжгүй болсон байдаг. Гэвч өмнөх гэрлэлтээ цуцлуулж дуусгавар болгосон ч хүүхэдтэй бол үүрэг хариуцлага хүлээсэн хэвээр байдаг. Энэ нь дахин гэрлэлтийн үед зөрчил үүсгэх тохиолдол бий учир хосууд энэ тал дээр харилцан ойлголцох нь зүйтэй бөгөөд нэгнээсээ нуух нь асуудлыг улам дэвэргэдэг. **Өмнөх гэрлэлтэй холбоотой асуудалтай** гэр бүл 2 буюу 13% байна.
- Дахин гэрлэж буй хүмүүст **нийгмийн зүгээс үзүүлж буй сэтгэл зүйн хүчирхийллийн асуудалтай** тулгарсан 1 гэр бүл буюу 7% байна.

ДҮГНЭЛТ

1. Дахин гэрлэсэн гэр бүл нь өмнөх гэрлэлтээс үлдсэн сэтгэлийн шарх, дахин гэрлэлтээ амжилттай болгох гэсэн санаа зовнилт, шийдвэрлэх асуудал ихтэй нарийн төвөгтэй бүтэц бүхий гэр бүлийн нэг хэлбэр юм. Монгол улс нь гэр бүл салалт болон салалтын шалтгаан үр дагаврын талаар хийсэн судалгаа цөөнгүй боловч дахин

гэрлэлтийн талаарх судалгаа, үйлчилгээ дутмаг байна. Монгол улсын хувьд гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээнд зааснаар гэр бүлийн хэрэгцээнд нийцүүлэн үзүүлэх үйлчилгээний ангилалд **дахин гэрлэсэн гэр бүлд нийгмийн ажлын үйлчилгээ, тэднийг дэмжин ажиллах үйлчилгээ** шаардлагатай.

2. Монгол улс дахь дахин гэрлэсэн гэр бүлийн талаар суурь судалгаа, тоо баримт дутмаг учир үүнтэй холбоотой судалгаа хийж, мэдээллийн сантай болох. Ингэхдээ судалгаанд гэр бүлийн бүтэц, харилцааны онцлогийг тодруулах, тулгамдаж буй асуудал, түүнийг шийдвэрлэх аргыг илрүүлэхээр тусгасан байх.
3. Дахин гэрлэлт болон дахин гэрлэсэн гэр бүлийн талаарх ойлголт, хандлагыг олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан дээшлүүлэх.
4. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 237 дугаар тогтоолоор улсын хэмжээнд 833 Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажиллахаар шийдвэрлэсэн бөгөөд үйлчилгээ үзүүлэх гэр бүлийн төрөлд дахин гэрлэсэн гэр бүлийг багтаах нь тухайн гэр бүлд өсөж буй хүүхдэд тулгарч буй асуудал бэрхшээлийг илрүүлэх, туслалцаа үзүүлэх боломж бий болно.

5. Монгол Улсад ч мөн олон улсын сайн туршлагад тулгуурлан дахин гэрлэгчдэд зориулсан тусгай хөтөлбөр, зөвлөгөөний үйлчилгээг үе шаттайгаар нэвтрүүлэх, мэргэжлийн нийгмийн ажилтнуудыг бэлтгэх, нийгмийн ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэх нь нэн шаардлагатай байна. Энэ нь зөвхөн гэр бүлийн тогтвортой байдлыг дэмжих төдийгүй хүүхдийн эрхийг хамгаалах, нийгмийн эрүүл уур амьсгалыг бүрдүүлэх үндэс болох юм.

НОМ ЗҮЙ

1. (2025). Улаанбаатар хот: Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
2. Cartwright. C., G. K. (2012). *The effects of co-parenting relationships with ex-spouses on couples in step-*

- families. . Australian Institute of Family Studies*
3. Hetherington, E. M. (2000). *Coping with divorce, single-parenting, and remarriage: A risk and resiliency perspective*
4. (2022). Гадаад ажил эрхлэлтийн гэр бүлд үзүүлэх нөлөөлөл. Улаанбаатар хот : Санхүү, эдийн засгийн их сургууль
5. (2021). Гэр бүлийн хөгжлийн үнэлгээ: Судалгааны тайлан Улаанбаатар хот: Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.
6. (2023). Монгол гэр бүл дэх гуравдагч этгээдийн оролцооны судалгаа. Улаанбаатар хот : Гэр бүл судлалын төв
7. (2023). Монгол Улс дахь гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдал. Улаанбаатар хот: Хүний эрхийн үндэсний комисс
8. Оюун-Эрдэнэ.Б. (2012). Монгол гэр бүлийн бүтэц, хэв маяг, харилцааны онцлог, тулгамдаж буй асуудал. 37-49